



НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А112

Улаанбаатар хот

Шуурхай зөвлөгөөний дэг
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, газрын хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.1, 2.1.11, 2.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтлэг үйлчилгээний газрын шуурхай зөвлөгөөний дэгийг 1 дүгээр хавсралтаар, шуурхай зөвлөгөөнд оролцох албан тушаалын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, шуурхай зөвлөгөөн зохион байгуулах хуваарийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шуурхай зөвлөгөөний дэгийг 2022 оны 03-р сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Шуурхай зөвлөгөөний дэг, хуваарийг нийт албан хаагчдад танилцуулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Ч.Шинэчимэг)-т даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2021 оны А/05 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДЭЛГЭР

Нийтлэг үйлчилгээний газрын даргын
2022 оны 03 дугаар сарын 01 –ны өдрийн
А/А дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

**НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ШУУРХАЙ
ЗӨВЛӨГӨӨНИЙ ДЭГ БАТЛАХ ТУХАЙ.**

Нэг. Зөвлөгөөнд бэлдэх.

1. Газрын захиргааны ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг /цаашид “шуурхай зөвлөгөөн” гэх/ хийхэд энэхүү дэгийг баримтална.
2. Шуурхай зөвлөгөөний бэлтгэл хангуулах ажлыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга хариуцана.
3. Шуурхай зөвлөгөөн хийх хуваарийг оны эхэнд гаргаж, албад хэлтсийн дарга нарт өгч шаардлагатай тохиолдлоос бусад үед хуваарийн дагуу хийнэ.
4. Шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг даалгаврын биелэлт, илтгэх хуудсыг шуурхай зөвлөгөөний өмнөх пүрэв гаригт багтаан шуурхай асуудал хариуцсан ажилтанд өгнө. Хугацаа хоцорсон буюу гарын үсэггүй илтгэх хуудас хүлээж авсанд тооцохгүй.

Хоёр. Шуурхай зөвлөгөөн хийх

1. Шуурхай зөвлөгөөнийг сард 2 удаа буюу Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний дараа зохион байгуулна. Хугацаа өөрчлөгдвөл жич зарлана.
2. Газрын даргын тушаалаар батлагдсан албан хаагчид зөвлөгөөнд оролцоно.
3. Шуурхай зөвлөгөөний ирцийг Шуурхай асуудал хариуцсан ажилтан бүртгэнэ.
4. Газрын шуурхай зөвлөгөөний тэмдэглэлийг Шуурхай асуудал хариуцсан ажилтан хөтөлнө.

Гурав. Шуурхай зөвлөгөөн доор дурьдсан журмыг баримтлана.

1. Шуурхай зөвлөгөөнийг газрын дарга даргалж явуулна. Газрын даргын эзгүйд газрын орлогч дарга зохион байгуулж болно.
2. Газрын хэмжээнд 14 хоногт хийсэн ажлын дүнг хэлэлцэж дараах 14 хоногт хийх ажил болон газрын өмнө тулгамдсан асуудлуудыг хэлэлцэнэ.
3. Шуурхай зөвлөгөөнд Нийслэлийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөр өгсөн үүрэг даалгаврыг мэдээлнэ.

Дөрөв. Шуурхай зөвлөгөөнд оролцогчдын хүлээх үүрэг.

1. Шуурхай зөвлөгөөнд оролцогчид нь өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь хэрэгжүүлэх ажлыг биечлэн зохион байгуулан, хяналт тавьж гүйцэтгэлийг газрын шуурхай зөвлөгөөн дээр танилцуулж ажиллана.
2. Шуурхай зөвлөгөөнийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр таслах, шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүргийг хугацаанд нь биелүүлээгүй, чанаргүй хийсэн, огт биелүүлээгүй тохиолдолд зохих журмын дагуу хариуцлага тооцно.

Нийтлэг үйлчилгээний газрын даргын
2022 оны 03 дугаар сарын 01 –ны өдрийн
А.1.2 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД
ОРОЛЦОХ АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

Удирдлага:

1. Газрын дарга
2. Орлогч дарга

Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс:

1. Хэлтсийн дарга
2. Ерөнхий нягтлан бодогч
3. Захиргааны ахлах мэргэжилтэн
4. Дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний ажилтан
5. Дотоод хяналт хариуцсан ажилтан
6. Хууль, эрх зүй, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ажилтан
7. Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч нар
8. Тооцооны нягтлан бодогч нар
9. Хүний нөөц, дотоод ажил хариуцсан ажилтан
10. Их эмч
11. Төлөвлөлт, тайлан мэдээ хариуцсан ажилтан
12. Шуурхай асуудал хариуцсан ажилтан
13. Архив, бичиг хэргийн эрхлэгч
14. Шуурхай асуудал хариуцсан ажилтан
15. Өргөдөл гомдол хариуцсан ажилтан
16. Сувилагч
17. Агентлаг хариуцсан нярвууд


Инженерийн байгууламжийн ашиглалт, үйлчилгээний алба:

1. Албаны дарга
2. Ерөнхий инженер
3. Цахилгааны инженер
4. Халаалт, агаар сэлгэлтийн инженер
5. Дулаан, сантехникийн инженер
6. Мэдээлэл, холбоо, дохиоллын инженер
7. Мэдээлэл, технологийн инженер

Үйлдвэрлэл, үйлчилгээний алба:

1. Албаны дарга
2. Байр хариуцсан менежерүүд
3. Зоогийн газрын менежер
4. Зоогийн газрын ерөнхий тогооч
- 5.

Нийтлэг уйлчилгээний газрын даргын
2022 оны 03 дугаар сарын 01 –ны өдрийн
10 дугаар тушаалын гуравдугаар
хавсралт



ГАЗРЫН ДАРГЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН
ЗОХИОН БАЙГУУЛАХ 2022 ОНЫ ХУВААРЬ

№	Сар	Өдөр	Цаг	Зохион байгуулах газар
1	1	10	14:00	Хангарьд ордны 14 давхарт Хурлын танхимд
2		24		
3	2	7		
4		21		
5	3	7		
6		21		
7	4	4		
8		18		
9	5	2		
10		23		
11	6	6		
12		20		
13	7	4		
14		25		
15	8	8		
16		22		
17	9	5		
18		19		
19	10	3		
20		17		
21	11	7		
22		21		
23	12	12		
24		26		